



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.06.23 № УИХ-01/7460


танай _____-ны № _____-т

Улсын Их Хурлын гишүүдийн
асуулт хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны Улсын Их Хурлын асуулгын цагаар Ерөнхий сайдад тавих Улсын Их Хурлын гишүүдийн асуултыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2-т “Гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна.” гэж заасны дагуу хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ⁵ ... хуудастай.

ДАРГА



С.БЯМБАЦОГТ

Монгол Улсын Их Хурлын 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн УИХ-01/1460 дугаар албан бичгийн хавсралт

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 26-ны өдрийн Баасан гарагийн нэгдсэн хуралдааны
Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайдаас асуухаар ирүүлсэн
Улсын Их Хурлын гишүүдийн асуулт**

№	Улсын Их Хурлын гишүүн	Асуулт
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ		
1	О.Цогтгэрэл	Сэдэв: Нийгмийн хамгаалал уу? Нийтийн халамж уу? • Нийгмийн хамгаалал уу? Нийтийн халамж уу?
2	Ц.Баатархүү	Сэдэв: Нийгмийн хамгаалал уу? Нийтийн халамж уу? - Таны тэргүүлж буй Засгийн газар, “ Нийгмийн хамгаалал ” (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, даатгалын тогтолцоог бэхжүүлэх) болон “ Нийтийн халамж ” (бэлэн мөнгө, тэтгэмж тараах) хоёрын зааг ялгааг хэрхэн харж байна вэ? Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын бодит үр дүн хэзээ гарах вэ?
3	П.Батчимэг	1."Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамруулах" гэсэн төсөл, арга хэмжээнд нийт 5906 хүнийг хамруулахад 46 тэрбум төгрөг батлуулсан ба энэ нь 1 хүнд 7,8 сая төгрөг ногдож байна. Энэ мөнгөөр дундаж давхаргыг хэрхэн нэмэгдүүлэх вэ? "Хөдөлмөр эрхлэлтийн сан" өнөөдөр нэг төрлийн нийгмийн халамжийн сан болсонтой санал нийлж байна уу? Энэ санг цаашид хэрхэн өөрчлөх вэ? 2.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд 2024 онд батлагдсан Ахмад настны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11, 9.12 дахь хэсэг, мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт өнөөдөр ямар байдалтай байна вэ? Ахмад настныг авч ажиллуулахад ажил олгогч байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Засгийн газраас ямар дэмжлэг, хөшүүрэг үзүүлж байна вэ?
4	Б.Жаргалан	Монгол Улс хавтгайрсан халамжийн тогтолцоотой болсон гэдэгтэй та санал нэг байна уу? Халамж хавтгайрсан байдлыг халах чиглэлээр ямар дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ?
5	Ц.Мөнхтуяа	Сэдэв: Нийгмийн хамгаалал уу? Нийгмийн халамж уу? Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн

		<p>даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд тэтгэвэр тогтоолгох насыг үе шаттай нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох дундаж хугацааг уртасгах зэрэг зохицуулалт тусгагдсан байна. Нөгөө талаас улсын төсвөөс олгож буй олон төрлийн халамжийн хөтөлбөрүүд жилээс жилд нэмэгдэж, хөдөлмөр эрхэлж шимтгэл төлсөн иргэдийн нийгмийн хамгааллын баталгаа харьцангуй сулрах хандлага ажиглагдаж байна.</p> <p>1.Монгол Улсын Засгийн газар цаашид нийгмийн хамгааллын тогтолцоог хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлсөн иргэдийн эрх ашигт тулгуурлан бэхжүүлэх бодлого баримталж байгаа юу, эсвэл төсвийн боломжид тулгуурласан нийтийн халамжийн тогтолцоог өргөжүүлэх бодлого баримталж байгаа юу?</p> <p>2.Монгол Улсын Засгийн газраас хөдөлмөрийн онцгой нөхцөлд ажилладаг, улсын хөгжлийн тэргүүлэх салбар болсон боловсрол, эрүүл мэндийн салбарын багш, эмч, бусад ажилтнуудад эрт тэтгэвэр тогтоолгох, тэтгэвэр тогтоолгох аргачлал, нэг удаагийн тэтгэмж олгох зэрэг ялгамжтай нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх боломжийг судалсан эсэхээ тодорхой хариулна уу.</p>
6	Р.Сэддорж	<p>Сэдэв: Нийгмийн хамгаалал уу? Нийтийн халамж уу?</p> <ul style="list-style-type: none"> Монгол Улсын Засгийн газраас нийгмийн халамжийг бууруулах чиглэлд ямар бодлого баримталж ажиллаж байгаа вэ?
7	Д.Цогтбаатар	<ul style="list-style-type: none"> Монгол Улс иргэдээ халамжаар тэтгэдэг тогтолцооноос хөдөлмөр, үйлдвэрлэл, баялаг бүтээхийг дэмждэг тогтолцоонд хэзээ шилжих вэ?
8	С.Цэнгүүн	<ul style="list-style-type: none"> Эрчим хүчний салбарт анх удаа зохион байгуулагдсан аукционтой холбогдуулан шалгарсан компаниудын тухай; цаашид авах арга хэмжээ; үүнтэй холбоотой Эрчим хүчний зохицуулах хорооны бие даасан байдлыг хэрхэн хангах тухай.
9	Ө.Шижир	<p>1.Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд болон үеийн сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж халамжийн бодлогыг бууруулахаар тусгадаг боловч бодит нөхцөлд хэрэгждэггүйгээр барахгүй эсрэгээрээ байдаг.</p> <p>Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас "Халамжаас хөдөлмөрт" шилжих зорилтыг тунхаглаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээ илэрхийлсэн ч бусад халамжийн хөтөлбөрүүд нь ажиллах хүчний идэвхийг бууруулж, хувийн хэвшлийнхэнд ажиллах хүчний хомсдол үүсгэх гол шалтгаан болж байна гэх шүүмжлэл байна.</p> <p>Иймд Засгийн газар иргэдийг халамжаас хөдөлмөрт шилжүүлэх бодлогыг цаашид хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ? эсвэл нийт иргэдэд чиглэсэн өргөн хүрээний халамжийн тогтолцоог цаашид хэвээр хадгалах нь зөв гэж үзэж байна уу?</p> <p>2.Улс орны эдийн засгийн гол ачааг үүрч, татварын орлогын</p>

		<p>дийлэнх хэсгийг бүрдүүлдэг дундаж давхаргын иргэд орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлээ бүрэн төлж, нийгмийн хамгааллын тогтолцоог санхүүжүүлэхэд хамгийн их хувь нэмэр оруулдаг. Гэвч бодит байдал дээр тэд төрөөс олгодог олон төрлийн халамж, тэтгэмжийн хөтөлбөрөөс ихэвчлэн гадуур үлддэг. Мөн өндөр хэмжээний шимтгэл төлдөг хэдий ч эргээд хүртэх ёстой нийгмийн хамгааллын үйлчилгээ нь хангалттай түвшинд хүрч чадахгүй байна.</p> <p>Тухайлбал, дундаж орлоготой иргэд олон жилийн турш нийгмийн даатгалын шимтгэл төлсөн ч ирээдүйд авах тэтгэврийн хэмжээ нь амьжиргааны хэрэгцээг бүрэн хангахуйц түвшинд хүрэх эсэх нь эргэлзээтэй хэвээр байна. Мөн улсын эрүүл мэндийн даатгалд тогтмол хамрагддаг боловч эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүйгээс шалтгаалан хувийн эмнэлэгт нэмэлт зардал гаргах шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, тэд нэг талаас татвар, шимтгэлээрээ нийгмийн хамгааллын тогтолцоог санхүүжүүлж байгаа ч нөгөө талаас чанартай үйлчилгээ авахын тулд дахин хувийн зардал гаргаж байна. Мөн хөдөлмөр эрхлэх, албан ёсны орлогоо тайлагнах, нийгмийн даатгалд хамрагдах сонирхол буурч, улмаар нийгмийн хамгааллын системийн санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэх боломжтой юм.</p> <p>Ийм нөхцөлд хөдөлмөрлөж, шимтгэлээ шударгаар төлж буй дундаж давхаргынхны эрх ашиг, нийгмийн хамгааллын баталгааг сайжруулахын тулд Засгийн газар ямар бодит шинэчлэл хийхээр төлөвлөж байгаа вэ? Мөн тэдний төлсөн татвар, шимтгэлд дүйцэхүйц үр өгөөжийг хэрхэн бий болгох вэ?</p> <p>Дээрх асуудлыг шийдвэрлэх талаар Засгийн газарт бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээ зорилт үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа эсэх талаар мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганд танилцуулж өгнө үү.</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
10	С.Эрдэнэболд	<p>Сэдэв: Нийгмийн хамгаалал уу? Нийтийн халамж уу?</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нийт иргэдийн хэдэн хувь нь халамж хүртэж байна вэ?
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ		
11	Л.Соронзонболд	<p>Асуултын хүрээ: Хууль тогтоомжийн биелэлт Асуулт 1 Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас нас барсан болон хөдөлмөрийн чадвараа алдсан нэр бүхий 112 иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Алтангэрэлийн нэхэмжлэлтэй, Засгийн газар хариуцагчаар оролцсон Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн №0404 тоот шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн №570</p>

		<p>тоот магадлал зэргийн биелэлт хангагдахгүй 4 жил болж байгаа шалтгаан нь юу байна вэ?</p> <p>Дээрх Шийдвэр болон Магадлалын биелэлтийг хангах асуудал нь 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтын 13 дугаарт орж байгаад зарим яамдаас санал аваагүй үндэслэлээр хэлэлцэхийг хойшлуулсан, гэвч өнөөдөр бүх яамдаас саналыг авч дууссан боловч өнөөг хүртэл хэлэлцээгүй байна.</p> <p>Засгийн газар нь Шүүх болон Арбитрт хариуцагчаар оролцсон тохиолдолд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах хууль эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас энэ асуудал үүсээд байна уу?</p> <p>Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн "11.5.5. Засгийн газар олон улсын шүүх, арбитрт хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах зардлыг хариуцах;" гэж заасан байгаа боловч Монгол Улсын Шүүх, Арбитрт Засгийн газар хариуцагчаар оролцсон тохиолдолд шийдвэрийн биелэлтийг хэрхэн хангах талаар эрх зүйн орчин дутагдалтай байна уу?</p> <p>Асуултын хүрээ: Эдийн засаг, нийгмийн асуудал</p> <p>Асуулт 2</p> <p>Эрдэнэс Тавантолгой төрийн өмч давамгайлсан хувьцаат компани нь нүүрсний арилжааг уул уурхайн биржээр дамжуулан амжилттай борлуулж байгаа, харин нүүрс тээврийг Төрийн Худалдан авах ажиллагааны газраар дамжуулж, хамгийн бага үнийн саналаар тендер шалгаруулж явуулж байна. Энэхүү нүүрс тээврийн тендерт нүүрс худалдан авагчдыг төлөөлж буй тээврийн компаниуд нүүрс тээврийн бодит өртгөөс бага үнээр оролцож байгаа нь энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй 610 аж ахуйн нэгж, эдгээр аж ахуйн нэгжээр дамжуулж тээвэр хийж буй 10 мянга гаруй жолооч, иргэдийн бизнес, амьдралд хүндээр тусаж, татвар, зээлээ төлж чадахгүй байдалд хүргэж байна.</p> <p>Нүүрс тээврийн салбарын 545 ААН 2024 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 431.7 тэрбум төгрөг төлж байсан ба 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 187 ААН 32.4 тэрбум төгрөгийн ААНОАТ-ын өртэй байна.</p> <p>Хүнд даацын автомашинаар нүүрсний тээвэр хийж, амьжиргаагаа залгуулж буй 6,000 гаруй иргэн 265.1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бол 640 гаруй аж ахуйн нэгж 469.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа ба нийт зээлийн 10 гаруй хувь нь хугацаа хэтэрч, чанаргүй ангилалд орж, зээлээ төлж чадахгүй байдалд байна.</p> <p>Нүүрс борлуулж буй төрийн өмчийн компани нь ашгаа нэмэгдүүлэхийн тулд нүүрс тээврийн салбарын хувийн компани, иргэдийг хохироож, Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.5-д заасан ноёлох үйл ажиллагаа явуулж байгаа энэхүү асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж байна вэ?</p> <p>Асуултын хариуг бичгээр авна.</p>
12	Ж.Галбадрах	<p>1.Сургуулийн хүртээмж, багшийн тоон болон чанарын хомсдол</p> <ul style="list-style-type: none"> • 108 сургууль, 95 цэцэрлэг барих төсвийн хэрэгжилтийн хувь, хугацаа, чанарын хяналт ямар байна вэ? Хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд

		<p>ямар хариуцлага тооцож байна вэ?</p> <ul style="list-style-type: none"> • Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хөнгөлөлттэй зээлийн ашиглалт зориулалтын дагуу явагдаж байна уу? Ил тод байдал, хяналт хэр хангагдаж байна вэ? • Багшийн (ялангуяа мэргэжлийн багшийн) хомсдолын тоон үзүүлэлт, нийт хэдэн багш дутагдалтай байна вэ? Бүс нутгийн ялгаа ямар байна вэ? Авч буй арга хэмжээний үр дүн юу вэ? Багшийн чанарын хомсдолын чанарын судалгаа байна уу? <p>2.Нэг аймагт 1 Кембриж сургууль</p> <ul style="list-style-type: none"> • Нэг сургуульд зарцуулагдах нийт төсөв, лицензийн болон бусад гадаад төлбөр ямар хэмжээтэй вэ? • Энэ санаачилга боловсролын чанарын ялгааг улам гүнзгийрүүлэх, төр өөрөө бодлогоор давхар стандарт бий болгох эрсдэл байхгүй юу? Хүртээмжийн хувь, эдийн засгийн өгөөж, нийгмийн тэгш байдалд үзүүлэх нөлөөг тооцоолсон судалгаа бий юу? • Одоо ажиллаж буй Кембриж хөтөлбөртэй сургуулиудын туршлагаас ямар дүгнэлт гаргаж байна вэ? Ялангуяа зарцуулсан зардал болон гарч буй үр дүнд хийсэн дүн шинжилгээг танилцуулах боломжтой юу? <p>3.Хиймэл оюун ухаан, хүүхэд бүрд 1 компьютер – 1 багшид 1 туслах, сурагчийн туслах</p> <ul style="list-style-type: none"> • Финланд, Швед зэрэг боловсролын чанараар тэргүүлэгч орнууд дижитал шилжилтээс ухарч буй. Тэднээс Монгол Улс ямар сургамж авах ёстой вэ? • Монголын нөхцөлд (интернэт, цахилгаан, багшийн чадвар) AI-г багшийн туслах болгон нэвтрүүлэх үе шаттай, тэнцвэртэй стратеги юу байх вэ? • Боловсролын чанарт үзүүлэх бодит нөлөө, төсвийн зарцуулалтын эрэмбэ дарааллыг (суурь ур чадвар → багш → AI) ямар байдлаар тодорхойлж байна вэ?
ХҮН НАМЫН ЗӨВЛӨЛ		
13	Г.Уянгахишиг	1.ХХОАТ-ын хууль дээр бид анхан шатны нөлөөлөл үзүүлэх өөрчлөлтийг баталлаа. Цаашид илүү бодлогын өөрчлөлтийг хийх шаардлагатай. Үүн дээр ямар бодлогын төлөвлөгөө байна вэ?
14	Л.Энхнасан	1.Нийгмийн даатгалын тогтолцооны өөрчлөлтийг хэрхэн харж байна вэ? Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлтөөр цаашид нийгмийн даатгалын сан алдагдалгүй хэвийн үргэлжлэх боломжийг бий болгож чадсан гэж харж байна уу?